

Virginia Preschool Initiative (VPI) Хөтөлбөрт өргөдөл гаргах журам:

- 1. Утсаар заавал ярилцлага хийх:** 703-228-8632 (Англи) эсвэл 703-228-8000, сонголт 1 (Испани) тоот утсаар залгаж VPI-н шаардлагад нийцэх эсэхийг тодруулах ёстой.
- 2. Шаардлага хангаж буй гэр бүлүүд биечилж уулзах цаг товлох:** Шаардлага хангаж буй гэр бүлүүд АУС-н ажилтантай биечилж уулзан шаардлагатай бичиг баримтууд бүрдүүлж, өргөдөл гаргана.
- 3. Өргөдөл Илгээх:** Өргөдлийг зөвхөн биечилсэн уулзалтын үед гаргах боломжтой.

Шаардлагатай бичиг баримтууд

VPI хөтөлбөрт өргөдөл гаргахын тулд дараах бичиг баримтуудыг биечилсэн уулзалтын үеэр бүрдүүлж өгнө:

- 1. Хүүхдийн нас, нэр тодорхойлох-** Хүүхэд 2025 оны 9-р сарын 30-с өмнө 4 нас хүрсэн байх ёстой.
 - Төрсний Гэрчилгээний эх хувь- Төрсний Гэрчилгээ Англи хэлээр биш бол албан ёсны орчуулга шаардлагатай.
- 2. Хаяг тодорхойлох-** Эцэг эх/ Асран хамгаалагч нь хүүхдийн хамт Арлингтон хотод оршин суудаг гэдгийг нотлох.
Хэрэв хүүхдийн эцэг эх нь орон сууц эзэмшдэг, эсвэл түрээсэлдэг бол- дараах ГУРВАН (3) баримт шаардлагатай.
Дараах жагсаалтаас аль НЭГ (1) бичиг баримт:
 - Deed- Хүүхдийн эцэг эх нь Арлингтонд орон сууц эзэмшиж, амьдардаг нотолгоо.
 - Хүчинтэй Түрээсийн Гэрээ (Lease Agreement)- Түрээсийн гэрээ нь хүүхдийн эцэг эх/Асран хамгаалагчийн нэр дээр байх бөгөөд түрээслэгч, түрээслүүлэгч нар гарын үсэг зурсан байх ёстой.
 - Орон сууц худалдан авах гэрээ (Settlement)- Шинээр орон сууц худалдан авсан бөгөөд гэрчилгээ хараахан гараагүй нөхцөлд
МӨН
Эцэг эх/асран хамгаалагчийн нэр, хаяг бүхий дараах бичиг баримтуудаас Хоёр (2) ширхэг шаардлагатай:
 - Тухайн жилийн Холбооны, мужийн эсвэл хөрөнгийн татварын тайлан, сүүлийн цалингийн тайлан, Тээврийн Хэрэгслийн бүртгэл, ахуйн хэрэглээний төлбөрийн нэхэмжлэл, одоогийн хаягтай Виржина мужийн жолооны үнэмлэх, Арлингтон хотоос олгодог халамж, тэтгэмжийн баримт, банкны дансны хуулга, хаяг дээр гарсан Түрээслэгчийн даатгалын гэрээ, Сонгогчийн Үнэмлэх, Татварын 1099 юм уу W2 маягтууд.

Өөр айлын хаягт түр амьдарч буй гэр бүлүүд- Хүүхдийн хамт өөр айлд амьдарч буй эцэг эх/ асран хамгаалагч нь дараах ТАВАН (5) баримт шаардлагатай.

Дараах бүх Гурван (3) бичиг баримт шаардлагатай

- Form A- Parent/Legal Guardian/Adult Student Residency Affidavit/ Хүүхдийн эцэг эхийн хаяг тодорхойлох хувийн баталгаа
- Form B- Statement of Arlington Resident Affidavit. / Арлингтоны оршин суугчийн хаяг тодорхойлох хувийн баталгаа
- Deed эсвэл Current Lease Agreement эсвэл Settlement Documentation - Сууц эзэмших гэрчилгээ/ Сууц худалдан авах гэрээ юм уу Түрээсийн Гэрээ. (Settlement- Шинээр орон сууц худалдан авсан бөгөөд гэрчилгээ хараахан гараагүй нөхцөлд)
МӨН

Эцэг эх/асран хамгаалагчийн нэр, хаяг бүхий дараах бичиг баримтуудаас Хоёр (2) ширхэг шаардлагатай:

- Тухайн жилийн Холбооны, мужийн эсвэл хөрөнгийн татварын тайлан, сүүлийн цалингийн тайлан, Тээврийн Хэрэгслийн бүртгэл, ахуйн хэрэглээний төлбөрийн нэхэмжлэл, одоогийн хаягтай Виржина мужийн жолооны үнэмлэх, Арлингтон хотоос олгодог халамж, тэтгэмжийн баримт, банкны дансны хуулга, хаяг дээр гарсан Түрээслэгчийн даатгалын гэрээ, Сонгогчийн Үнэмлэх, Татварын 1099 юм уу W2 маягтууд.

"Residency Forms A" and B" Маягтуудыг АУС-н вэбсайтаас татаж авах: <https://www.apsva.us/registration/required-documents/>

- 3. Эцэг эхийн биеийн байцаалт-** эцэг эх/ асран хамгаалагч нь засгийн газраас олгосон хүчинтэй зураг бүхий биеийн байцаалттай байх ёстой.
 - Төрийн байгууллагаас олгосон зураг бүхий биеийн байцаалт, эсвэл Жолооны Үнэмлэх юм уу Паспорт
- 4. Орлого тодорхойлох-** VPI Хөтөлбөрт тэнцэх эсэхийг тодорхойлохын тулд тухай өрхийн орлого шаарддаг.
Хүүхдийн эцэг эх тус бүр дараах бичиг баримтуудаас **Нэг (1)** шаардлагатай:
 - 2023 Tax Return (1040)- 2023 оны W-2 эсвэл 1099 forms г.м татварт ашигласан баримтуудын хамт
 - Сүүлийн 3 цалингийн тайлан (Paystubs)- Эцэг эхийн заасан хугацаанд олсон цалин, орлогын тайлан
 - Ажлын Газрын тодорхойлолт- Ажил олгогч компанийн албан бланк дээр ажилтны нэр, нийт орлого, ажилласан нийт цаг, цалин тавих хуваарь зэргийг дурдах ба ажил олгогч гарын үсэг зурж, огноог бичсэн байх.
 - Temporary Assistance for Needy Families (TANF), Supplemental Security Income (SSI), Medicaid, or Supplemental Nutrition Assistance Program (SNAP). Хэрэв эцэг эх нь ажилгүй бол VPI -д тэнцэх эсэхийг тодорхойлохын тулд эдгээр халамжийн тэтгэмжүүдийг баталгаажуулсан албан ёсны шийдвэр, захиаг үндэслэл болгоно.
 - Хэрэв хүүхэд IEP-д хамрагддаг бол тусгай боловсролд хамрагдах эрх үүссэн тухай захиа юм уу хүчинтэй хэрэгжиж буй IEP (ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө) шаардлагатай.

Virginia Preschool Initiative (VPI) Хөтөлбөрт гаргасан өргөдөл дээрх шаардсан бичиг баримтуудыг хавсаргаагүй нөхцөлд өргөдлийг хүлээн авахгүй. Сургуулийн өмнөх насны VPI хөтөлбөрт сурагч элсүүлэх шийдвэр нь тухайн VPI Хөтөлбөрийн зүгээс тавьдаг нөхцөл шаардлагын дагуу зохицуулагдана. АУС-ийн VPI хөтөлбөрийн тухай дэлгэрэнгүйг дараах холбоосоор үзнэ үү: <https://www.apsva.us/early-childhood-prek/virginia-preschool-initiative-vpi/>